*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 8 дугаар хавсралт*

## БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

## ЭРХЭМБАЯР ОВОГТОЙ МӨНХЦЭЦЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусcан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1: Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх** | | | | | | | |
| | Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал | Хэрэгжилт,хувиар, гүйцэтгэлээр | Тайлант хугацаанд импортын нийт 2873, экспортын 76 мэдүүлгийн бичиг баримтыг нягтлан шалгаж гаалийн бүрдүүлэлт хийсэн байна. Импортын 2873 мэдүүлгээр 11500 нэр төрлийн, 103.8 сая ам долларын статистик үнийн дүн бүхий барааны бичиг баримтыг нягтлан шалгаж гаалийн бүрдүүлэлтийг хийсэн ба 45.7 тэрбумын төгрөг, 25.1 сая төгрөгийн хураамжийг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн байна. | Бичиг баримтын бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангахад Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар,ГЕГ-ын даргын А/30 тушаал импортын барааны гаалийн үнийг шалгах заавар, Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам, болон бусад хууль эрх зүйн акт, дүрэм, журам зааврын хүрээнд бичиг баримтын шалгалтыг алдаагүй хийж, зохих төлөвт бүрэн байршуулсан байна. | Барааны бичиг баримтын шалгалтыг хийхдээ ГЕГ-ын даргын баталсан гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх журам, заавар болон холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажилласан. Тайлант хугацаанд импортын нийт 3856, экспортын 53 мэдүүлгийн бичиг баримтыг нягтлан шалгаж гаалийн бүрдүүлэлт хийсэн байна. Импортын 3856 мэдүүлгээр 24075 нэр төрлийн барааны бүрдүүлэлт хийснээс үнэлгээний 1-р арга буюу хэлцлийн үнийн аргаар 18001 бараа, бусад арга буюу уялдуулан хэрэглэх үнийн аргаар 6074 барааны гаалийн үнийг хянаж, нийт 61.8 тэрбум төгрөгийн татвар, 34.7 сая төгрөгийн хураамжийг тус тус ногдуулсан байна. | 2024.01.01 2024.06.10 | 100 |
| 2. | Хууль ёсны гадаад худалдааг | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Бүрдүүлэлтийн цахим төвийн хэмжээнд цахимаар | Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр гарсан | Бүрдүүлэлтийн цахим төвийн хэмжээнд цахимаар өөрөө мэдүүлсэн нийт 20504 | 2024.01.01 2024.06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | | өөрөө мэдүүлсэн нийт 15290 гаалийн бүрдүүлэлт байгаа бөгөөд үүнээс 143 гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтын хяналтыг хийж, цахимаар өөрөө мэдүүлж буй иргэн, ААН-үүдэд гаалийн холбогдох хууль тогтоомж болон мэдүүлгийн алдааны талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. | бодлогын баримт бичиг, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, бараагаа өөрөө мэдүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх, цахимаар өөрөө мэдүүлж буй иргэн ААН болон Гаалийн итгэмжлэгдсэн ААН-ийн гаалийн бүрдүүлэлтийг түргэн шуурхай хийх, гаалийн мэдүүлэг болон бичиг баримтанд хяналт тавин ажилласан байна. | гаалийн бүрдүүлэлт байгаа бөгөөд үүнээс 424 гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтын хяналтыг хийж, цахимаар өөрөө мэдүүлж буй иргэн, ААН-үүдэд гаалийн холбогдох хууль тогтоомж болон мэдүүлгийн алдааны талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.<br>2025.05.01-нд Бүрдүүлэлтийн цахим төвөөс зохион байгуулсан цахимаар өөрөө мэдүүлэгч иргэн, ААН-үүдтэй хийсэн сургалт, уулзалтанд оролцсон. | | |
| 3. | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - УБ транс ХХК-ийн Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нь 2024.03.27-ний өдөр 03-2091008-24-I31084 сүлжээ дугаараар Металл-Опт ХХК-ийн гаальд мэдүүлсэн барааны гарал үүсэл дээрх БТКУС кодыг буруу мэдүүлсэн зөрчил гаргасан тул харьяаллын дагуу Замын-үүд ГГ-ийн зөрчил хариуцсан ГУБ-д шилжүүлж ЗШШТХ-ийн 11.21.14-дэх хэсгийг үндэслэн торгуулийн арга хэмжээ авсан. | Гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтын хяналтыг хэрэгжүүлж ажиллахдаа гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ГБМ-ээс шалтгаалах мэдүүлгийн алдааг тухай бүр засуулж ажиллана. | Гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтын хяналтыг хэрэгжүүлж ажиллахдаа гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ГБМ-ээс шалтгаалах мэдүүлгийн алдааг тухай бүр засуулж ажилласан. Тайлант хугацаанд нийт 825 удаагийн засварт буцаалтаар гаалийн мэдүүлэгт гарсан алдааг хянаж засуулсан.<br>Бүрдүүлэлтийн цахим төвөөс баталсан ГУБ нарт хувиарлаж өгсөн барааны бүлгийн дагуу 9018-9033 бүлгийг хариуцан тухайн бүлэгт хамаарах барааны бткус код, унификацийг жигдрүүлэх ажлын хүрээнд ГБМ-ээс шалтгаалах алдааг бүлэг хариуцсан ахлах байцаагч болон бичиг баримтын ГУБ нартай хамтран тухай бүр засуулж, барааны бичлэгийг хянаж ажилласан. | 2024.01.01<br>2024.06.10 | 100 |
| 4. | Барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойлох чиглэлээр зохион байгуулсан ажил | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2024 оны 01 дүгээр сард барааны ангилал, гомдол маргаан хариуцан ажиллах хугацаанд 21-ээс 29-р бүлгийн үнийн мэдээллийн санг баяжуулах чиглэлээр 165340 барааны бичлэгийг хянаж үнийн мэдээллийн | Хариуцсан бүлгийн барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх чиглэлээр барааны судалгаа хийх, унификацийг жигдрүүлэх ажлыг | 1. Тайлант хугацаанд хариуцсан бүлэг болох 9018-9033р бүлэгт хамаарах нийт 7268 барааны бичлэгийг хянаж хэлцлийн үнийн баазад оруулахаар, 218 барааг нягтлан шалгах саналтай илгээсэн.<br>2. БТКУС-ийн 9018-р бүлэгт хамаарах барааны 2025 оны эхний улиралд | 2024.01.01<br>2024.06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | санд илгээсэн. Алдаатай 10 барааны бичлэгийг нягтлан шалгах шаардлатай жагсаалтад хянаж, оруулсан.<br>Гаалийн үнийн хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БТКУС-н 8703-д хамаарах солонгос суудлын автомашины үнийн судалгаа мөн 8705-д хамаарах бетон зуурагч, 6810-д хамаарах цементэн хавтан, 6904-д хамаарах тоосго зэрэг зарим нэрийн барааны судалгааны үнийг баримтлан, үнийн нэгдмэл байдлыг хангаж ажилласан. | зохион байгуулсан байна. | хийсэн гаалийн бүрдүүлэлийн алдааг хянаж тус кодонд хамаарахгүй барааны жагсаалтыг гарган тус бараануудын талаарх онцлог шинж, зориулалтын ялгааг тодорхойлсон судалгааг хийсэн. Мөн БТКУС-ийн 9021-кодод хамаарах барааны талаарх ойлголтыг ГУБ нарт өгөх үүднээс барааны англи нэршил, онцлог шинж, зориулалт зэргийг харуулсан PDF файл бүхий гарын авлага бэлтгэн БЦТ-ийн ГУБ нарт танилцуулсан.<br>3. БНСУ-аас импортлогдож буй 8703 суудлын автомашины үнийн судалгаа, ЗҮГГ-ын зарим барааны хил орчмын шинэчлэгдсэн үнийн судалгааг мөрдлөг болгон үнийн нэгдмэл байдлыг ханган ажиллаж байна. | | |
| **Зорилт 2: Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах** | | | | | | | |
| 5. | Гаалийн бүрдүүлэлтэд гарсан алдаа болон зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - УБ транс ХХК-ийн Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нь 2024.03.27-ний өдөр 03-2091008-24-I31084 сүлжээ дугаараар Металл-Опт ХХК-ийн гаальд мэдүүлсэн барааны гарал үүсэл дээрх БТКУС кодыг буруу мэдүүлсэн зөрчлийг харьяаллын дагуу Замын-үүд ГГ-т шилжүүлж ЗШШТХ-ийн 11.21.14-дэх хэсгийг үндэслэн торгуулийн арга хэмжээ авсан.<br>2024.01.09-ний өдөр иргэн С.Шихихутаг Mercedes-Benz, G550 маркийн автомашиныг анх гаальд мэдүүлэхдээ дуудлага худалдааны баримтыг хавсаргаагүй гэх зөрчлийг | Бичиг баримтын шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татвар, торгуулийн дүнг өмнөх оны мөн үеэс 2 хүртэл хувиар нэмэгдүүлнэ. | Тайлант хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтын шалгалт хийх явцад нийт 5 зөрчил илрүүлж 9.6 саяг төгрөгийн торгууль ногдуулсан. Үүнд:<br>1. Барааны гарал үүслийн баримтыг хуурамчаар үйлдсэн [redacted] ХХК, [redacted] ХХК-д хамаарах 2 зөрчилд ЗТХ-ийн 11.21.17-дахь хэсгийг үндэслэн тус тус 3,000,000 төгрөгийн торгууль.<br>2. [redacted] ХХК нь озоны үндэсний албанаас өгдөг тусгай зөвшөөрлийг дутуу мэдүүлсэн гэх зөрчилд ЗТХ-ийн 11.21.14 дахь хэсгийг үндэслэн 3,000,000 төгрөгийн торгууль,<br>3. [redacted] ХХК нь анх 1 нэр төрлийн бараа мэдүүлснийг жинг нягтлуулахаар засварт буцаахад бодит байдал дээр 3 нэр төрлийн бараа байсан нь тогтоогдож гаалийн татвараас зайлсхийсэн зөрчилд | 2024.01.01<br>2024.06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | УБГГ-ын зөрчлийн албанд шилжүүлж ЗШШТХ-ийн 11.21.12-дахь заалтыг үндэслэн торгуулийн арга хэмжээ авсан болно. | | ЗТХ-ийн 11.21.1.2-дахь заалтыг үндэслэн 491,996,.1 төгрөгийн торгууль,<br>4. Иргэн [redacted] нь Cadillac, CTS маркийн суудлын автомашиныг мэдүүлэхдээ эвдрэл мэдүүлээгүй гэх зөрчилд ЗТХ-ийн 11.21.12 дахь хэсгийг үндэслэн 200,000 төгрөгийн торгуулийг тус тус ногдуулсан. | | |
| 6. | Өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн байдал | | 2024 оны 01 болон 04 дүгээр сард барааны ангилал, гомдол маргааны хүлээн авах шийдвэрлэх хэсэгт хуваарийн дагуу ажилласан. 2024 оны 01 сард ажиллахдаа барааны ангилал, үнэ үнэлгээтэй холбоотой 14 аж ахуй нэгжийн гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, хариуг хүргүүлж ажилласан. Үүнээс ГУБ-ийн шийдвэрийг хэвээр үлдээсэн 5 шийдвэр, барааны үнийг дахин хянах 14 шийдвэрийг тус тус гаргасан байна. 2024 оны 04 дүгээр сард ажиллахдаа Гомдол, мэдээлэл хүлээн авах 7000-1280 дугаарын утсыг хариуцан ажиллаж давхардсан тоогоор 1314 дуудлага хүлээн авч, 1264 дуудлага бүртгэж ажиласан. | 1.Бичиг баримтын бүрдүүлэлтийн үе шатанд ирсэн өргөдөл, гомдолыг холбогдох хуульд заасан хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн байна. | 2025 оны 02 дугаар сард БЦТ-ийн өргөдөл гомдол, маргаан шийдвэрлэх БТКУС-ийн хэсэгт ажилласан. Ажиллах хугацаанд нийт 10 ААН, иргэний ирүүлсэн гомдол маргааныг хянаж шийдвэр гаргасан.<br>Гомдол маргаан хүлээн авах хэсэгт ажиллах хугацаандаа суудлын автомашины импортын 2024 он, 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд хийсэн гаалийн бүрдүүлэлтийн онцгой албан татварыг нягтлан шалгах ажлыг багаараа хийж гүйцэтгэсэн.<br>Нийт 22 автомашины онцгой албан татвар буруу ногдуулсан:<br>"Гааль зөвшөөрөв" төлөвтэй 6 мэдүүлэг Нөхөн төлүүлсэн татвар 19.3 сая төгрөг.<br>70001281 утсанд ирсэн үнэ үнэлгээтэй холбоотой гомдол мэдээллийг цаг тухай бүр нь хүлээн авч холбогдох албан тушаалтанд танилцуулж ажилласан. | 2024.01.01<br>2024.06.10 | 100 |
| **Зорилт 3: "Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх"** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт, гаалийн тариф, гарал үүслийн хяналт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Импортын нийт 22 төрлийн горимоор 2206 гаалийн бүрдүүлэлт, экспортын нийт 3 төрлийн горимоор 76 бүрдүүлэлт хийсэн байна. Мөн өдөр тутмын үйл ажиллагаандаа Япон-Монголын эдийн засгийн хэлэлцээр болон Ази-Номхон далайн худалдааны хэлэлцээрийн дагуу мэдүүлж буй барааны гарал үүслийн гэрчилгээг нягтлан шалгаж, хэлэлцээрийг хэрэгжүүлж ажилласан. | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. | Тайлант хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилтийг хангуулж ажиллан импортын нийт 27 төрлийн горимоор 24155 бараанд 3875 гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн байна.<br><br>Тариф, гарал үүслийн хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Япон-Монголын эдийн засгийн хэлэлцээр болон Ази-Номхон далайн худалдааны хэлэлцээрийн дагуу мэдүүлж буй барааны гарал үүслийн гэрчилгээг нягтлан шалгаж, хэлэлцээрийг хэрэгжүүлж ажилласан. Мөн бичиг баримтын шалгалт хийх явцад гарал үүслийг нотлох баримт байхгүй гаалийн мэдүүлгийг засварт буцааж гарал үүслийн гэрчилгээг гаргуулах, эсвэл гаалийн тарифыг ердийн тарифт шилжүүлж гаалийн бүрдүүлэлтийг хийсэн.<br><br>Бичиг баримтын шалгалтыг хийх явцад БНХАУ-ын гарал үүслийг шалгаж үзэн гарал үүслийн гэрчилгээг хуурамчаар үйлдсэн дараах 2 зөрчлийг илрүүлсэн.<br><br>- Замын-Үүд гаалийн газрын Э-транс хяналтын бүсэд Электрик энержи инженеринг ХХК-ийн 03-2091021-25-I00033 сүлжээ дугаараар мэдүүлсэн 3 нэр төрлийн барааны гарал үүслийн гэрчилгээг http://check.ecoccpit.net/ сайтаар шалгаж үзэхэд уг гэрчилгээ нь өөр ААН-д олгогдсон гэрчилгээ болох нь тогтоогдсон тул ЗТХ-ийн 11.21.17-дахь заалтыг үндэслэн 3,000,000 сая төгрөгийн торгууль ногдуулсан.<br>- 03-2241006-25-I00468 дугаартай мэдүүлгээр 3 нэр төрлийн барааг гаалийн байгууллагад мэдүүлэхдээ №CCPIT1102500014744 дугаартай гарал үүслийн гэрчилгээг гаалийн мэдүүлэгт | 2024.01.01<br>2024.06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хавсарган мэдүүлснийг бар кодоор нь шалгаж үзэхэд гэрчилгээний дугаар, барааны код зөрүүтэй гарч ирсэн ба өөр ААН-д олгосон гэрчилгээний мэдээллийг засварлаж хуурамчаар үйлдсэн болох нь тогтоогдсон тул ЗТХ-ийн 11.21.17-дахь заалтыг үндэслэн 3,000,000 сая төгрөгийн торгууль ногдуулсан. | | |
| 8. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам", "ГУБ-д цол олгон, хураах, сэргээх, цолны нэмэгдэл хөлс олгох журам", "ГУБ-ийн үйлчилгээний стандартын журам", "ГУБ-ий сахилгын дүрэм", "ГУБ-ийн ёс зүйн дүрэм" зэрэг хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой холбогдох саналуудыг өгсөн. | Гаалийн бүрдүүлэлттэй холбоотой хууль тогтоомж, журам, зааврыг боловсронгуй болгоход санал санаачлагатай ажилласан байна. | "Бүрдүүлэлтийн цахим төвийн дүрэм"-ийн төсөл боловсруулах ажилд багийн гишүүдийн хамтаар санал өгсөн.<br>Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ын төсөл<br>Импортын барааны гаалийн үнийг шалгах, гаалийн үнийг тодорхойлох заавар зэрэгт санал өгсөн. | 2024.01.01<br>2024.06.10 | 100 |
| 9. | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.ГЕГ-ын удирдлага, Захиргааны зөвлөл, мэргэжлийн зөвлөл, шуурхай хуралдаанаас өгсөн зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаварыг хэрэгжүүлж, биелэлтийг хугацаанд нь гаргаж тайлагнасан байна. | Шинээр гарсан хууль, тогтоомж эрх зүйн актыг тухай бүр танилцаж, мөрдлөг болгон ажиллаж байна.<br>1.Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 240 дүгээр тогтоолын дагуу оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материалыг ГАТ-аас чөлөөлсөн<br>2.ГЕГ-ын даргын 2025 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих" журам.<br>3.БОУАӨЯ-НЫ А/113 тушаал Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх худалдах журам<br>4. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 240 дүгээр | 2024.01.01<br>2024.06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтоолын дагуу оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материалыг ГАТ-аас чөлөөлсөн тогтоол зэрэг эрх зүйн актыг мөрдлөг болгон ажиллаж байна. | | |
| | **Зорилт 4: "Соён гэгээрүүлэх"** | | | | | | |
| 10 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | ГЕГ-ын удирдлага, Захиргааны зөвлөл, мэргэжлийн зөвлөл, шуурхай хуралдаанаас өгсөн зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, биелэлтийг хугацаанд нь гаргаж тайлагнасан байна. | ГЕГ-ын удирдлага, БЦТ-ийн удирдлага болон ГЕГ-ийн холбогдох алба хэлтэсүүд, шуурхай хуралдаанаас өгсөн зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаварыг тухай бүр хэрэгжүүлж, биелэлтийг хугацаанд нь тайлагнаж ажилласан. | 2024.01.01 2024.06.10 | |
| 11 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Ажиллах хугацаанд ирц бүрэн. Өвчтэй, чөлөөтэй, тасалсан цаг байхгүй. 2024 оны ээлжийн амралтыг 11 сард биеэр эдэлсэн. | Ажлын цаг ашиглалт 90 хувиас доошгүй байна. | Ажиллах хугацаанд ирц бүрэн. ГУАБ-ийн гаргасан хуваарийн дагуу амралтын өдөр, болон цаг сунгаж ажилласан. /Өвчтэй, чөлөөтэй, тасалсан цаггүй/ | 2024.01.01 2024.06.10 | |
| 12 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | | 2025.01.29-нд зохион байгуулагдсан эм, эмнэлэгийн хэрэгсэл импортлогчдын хэлэлцүүлэг уулзалтанд оролцсон. Хариуцсан бүлэг болох 9018-р бүлгийн хүрээнд эмнэлэгийн хэрэгсэл импортлогч ААН-үүдийн төлөөллөөс ирүүлж буй санал хүсэлт, тулгамдаж буй асуудал, кодны эргэлзээтэй барааны талаарх мэдээлэлтэй танилцсан. Гаалийн ерөнхий газраас татварын хууль тогтоомжийн шинэчлэл сэдвийн дор 2025.05.01-нд Бүрдүүлэлтийн цахим төвөөс зохион байгуулсан цахимаар өөрөө мэдүүлэгч иргэн, ААН-үүдтэй хийсэн сургалт, уулзалтанд оролцсон. | 2024.01.01 2024.06.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Гадаад дотоод болон ажлын байранд зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлэх | | 2024.01.16-ны өдөр ГЕГ-ын БАҮХ-ээс зохион байгуулсан БТКУС-ийн кодын анхаарах асуудлууд сэдэвт сургалт,<br>- 2024.05.02-ны өдөр ГЕГ-ын БАҮХ-ээс үнэ, үнэлгээний чиглэлээрх зохион байгуулсан танхимын сургалтад хамрагдсан.<br>- 2024.05.06-нд МҮХАҮ-ийн танхимд Монгол улсад гадаад худалдааг хөгжүүлэх төслийн хүрээнд зохион байгуулсан “Экспортын хөнгөлөлтийн систем, гарал үүсэл” сэдэвт сургалтанд хамрагдсан. | Гадаад дотоод болон ажлын байранд зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн байна. | Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/107 тоот тушаалаар БНСУ-ын Чёонан болон Сөүл хотуудад 2025 оны 04 дүгээр сарын 15-наас 04 дүгээр сарын 21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Олон улсын гаалийн ажилтнуудад зориулсан Уялдуулсан системийн сургалт”-д ГЕГ-ын БАҮХ-ийн ГУБ Ц.Урантуулын хамт оролцсон.<br>Ажлын байранд зохион байгуулагдсан сургалтуудад цаг тухай бүр бүрэн хамрагдсан. | 2024.01.01<br>2024.06.10 | 100 |
| 2. | Үйл ажиллагаатай холбоотойгоор холбогдох шинээр гарсан хууль, тогтоомж, тогтоол, журам, зааврыг тухай бүр уншиж судлан, хууль | | | Үйл ажиллагаатай холбоотойгоор холбогдох шинээр гарсан хууль, тогтоомж, тогтоол, журам, зааврыг тухай бүр уншиж судлан, хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулсан. байна | Үйл ажиллагаатай холбоотойгоор шинээр гаргасан хууль тогтоомж, ГЕГ-аас баталсан журам зааврыг цаг тухай бүрд нь уншиж танилцан гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | 2024.01.01<br>2024.06.10 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ | Э.МӨНХЦЭЦЭГ / ........................................ / | 2025.06.10 |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ЭРХЭМБАЯР ОВОГТОЙ МӨНХЦЭЦЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Бүрдүүлэлтийн цахим төв

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1: “Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх”** | | | | | |
| 1. | Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал | 53 | 9 | 62 | |
| 2. | Хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | 53 | 9 | 62 | |
| 3. | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа | 52.5 | 9 | 61.5 | |
| 4. | Барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойлох чиглэлээр зохион байгуулсан ажил | 54 | 8 | 62 | |
| **Зорилт 2: “Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах”** | | | | | |
| 5. | Гаалийн бүрдүүлэлтэд гарсан алдаа болон зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил | 54 | 9 | 63 | |
| 6. | Өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн байдал | 52 | 9 | 61 | |
| **Зорилт 3: “Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх”** | | | | | |
| 7. | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт, гаалийн тариф, гарал үүслийн хяналт | 52 | 8 | 60 | |
| 8. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 52 | 7 | 59 | |
| 9. | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | 52 | 8 | 60 | |
| **Зорилт 4: “Соён гэгээрүүлэх”** | | | | | |
| 10. | Үүрэг даалгаврын биелэлт | 52 | 8 | 60 | |
| 11. | Ажлын цаг ашиглалт | 58 | 9 | 67 | |
| 12. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 45 | 5 | 50 | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2. | | | | | |
| Дундаж оноо: | | | | 60.6 | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Гадаад дотоод болон ажлын байранд зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлэх | 100% | 15 | |
| 2. | Үйл ажиллагаатай холбоотойгоор холбогдох шинээр гарсан хууль, тогтоомж, тогтоол, журам, зааврыг тухай бүр уншиж судлан, хууль | 100% | 15 | |
| Дундаж оноо | | | 15 | |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| Дундаж оноо | | 7 | |

## 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| Дундаж оноо | | 8 |

## 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(70 хүртэлх оноо)* 60.6 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | *(7 хүртэлх оноо)* 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* |

| | |
|---|---|
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | 90.6 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга
*(албан тушаал)*

................................
*(гарын үсэг)*

/Э.Лхагвасүрэн/
*(албан хаагчийн нэр)*
2025.06.10
................................ *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Гаалийн улсын байцаагч
*(албан тушаал)*

....................................
*(гарын үсэг)*

/Э.Мөнхцэцэг/
*(албан хаагчийн нэр)*
2025.06.10
........................ *(огноо)*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

ГЕГ-ын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
*(албан тушаал)*

...............................
*(гарын үсэг)*

/Г.Энхтайван/
*(албан хаагчийн нэр)*
2025.06.25
........................*(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

ГЕГ-ын Хүний нөөцийн хэлтсийн Гаалийн улсын ахлах байцаагч
*(албан тушаал)*

...............................
*(гарын үсэг)*

/Ө.Тэгшээ/
*(албан хаагчийн нэр)*
2025.06.25
........................ *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

ГЕГ-ын дарга
*(албан тушаал)*

...............................
*(гарын үсэг)*

/Р.Отгонжаргал/
*(албан хаагчийн нэр)*
2025.06.25
........................ *(огноо)*